



УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ᠤᠪᠪᠰ ᠠᠶᠢᠮᠭᠢᠶᠢᠨ
ᠨᠢᠶᠭᠭᠠᠮ ᠡᠳᠢᠶᠢᠨ
ᠵᠠᠰᠭᠢᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ

УВС АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2019/04



**УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**

**УВС АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙДАЛ**

**4 сар
2019**

Улаангом хот

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН ХААНААС АВАХ ВЭ?

WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах тоглоом 

Валютын ханш 



©2017

аппликейшнаас

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛЭЭ АВААРАЙ

Data lab

тооллого судалгааны микро мэдээллийн сан



Social network

 www.facebook.com/StatisticMongolia/


 www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn

ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл	4
Статистик мэдээллийн өнгө, таних тэмдэг.....	5
Хэрэглэгчдэд лавлагаа	7
Товч танилцуулга	8
Захиргааны мэдээлэл	35
IV.Хөдөлмөр	39
VI. Нийгмийн даатгал, халамж	44
VIII. Эрүүл мэнд.....	46
XI. Байгаль орчин	49
XII. Гэмт хэрэг.....	51
XIV.Мөнгө, зээл	53
XV.Орон нутгийн төсөв.....	54
XVI.Гадаад худалдаа.....	56
XVII. Үнэ	57
XVIII. Хөдөө аж ахуй	61
XIX. Аж үйлдвэр.....	67
XXII. Барилга.....	69

ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ТАЙЛБАР :

1. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III , IV, V..... г.м)
I-XII жилийн эхний тухайн сарыг оруулсан өсөн нэмэгдэх дүнг харуулав.
2. Дараахь тэмдэглэлүүдийг ашиглав :
... мэдээлэл байхгүй
0.0 маш бага тоо
- гүйцэтгэл байхгүй
Д - дахин
3. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрөх тохиолдол байж болно.

4. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд танилцуулга дээрх QR кодыг ашиглан дэлгэрэнгүй мэдээллийг uvs.nso.mn сайтаас татан авч ашиглаж болно.



Үндэсний статистикийн хорооны даргын
2013 оны 12 сарын 06 өдрийн 113-т тоот
тушаалын гуравдугаар хавсралт

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ӨНГӨ, ТАНИХ ТЭМДЭГ

Д/д	Таних тэмдэг	Мэдээллийн нэр	Өнгө	Вэбийн өнгө R/G/B	Хэвлэлийн өнгө S/M/Y/K
1		Засаг захиргаа, нутаг дэвсгэр	Шар	255/212/0	0/15/100/0
2		Сонгууль	Шар	255/212/0	0/15/100/0
3		Хүн ам	Цайвар ногоон	128/195/66	55/0/100/0
4		Хөдөлмөр	Цайвар ногоон	128/195/66	55/0/100/0
5		Хүн амын амьжиргаа	Цайвар ногоон	128/195/66	55/0/100/0
6		Нийгмийн даатгал, халамж	Улаан	217/31/61	10/100/80/0
7		Боловсрол, шинжлэх ухаан	Шар	255/212/0	0/15/100/0
8		Эрүүл мэнд	Цайвар ногоон	128/195/66	55/0/100/0
9		Хүний хөгжил	Улаан	217/31/61	10/100/80/0
10		Соёл, аялал жуулчлал, биеийн тамир, спорт	Шар	255/212/0	0/15/100/0
11		Байгаль орчин	Ногоон	14/178/76	80/0/100/0
12		Гэмт хэрэг	Улаан	217/31/61	10/100/80/0

Д/д	Таних тэмдэг	Мэдээллийн нэр	Өнгө	Вэб-д R/G/B	Хэвлэлд S/M/Y/K
13		Үндэсний тооцоо	Хөх	23/71/158	100/85/0/0
14		Мөнгө, банк, даатгал	Хөх	23/71/158	100/85/0/0
15		Төрийн санхүү	Хөх	23/71/158	100/85/0/0
16		Төлбөрийн тэнцэл, гадаад худалдаа	Хөх	23/71/158	100/85/0/0
17		Үнэ	Хөх	23/71/158	100/85/0/0
18		Хөдөө аж ахуй	Улбар шар	248/165/26	0/40/100/0
19		Аж үйлдвэр	Цэнхэр	117/190/223	50/10/0/0
20		Тээвэр, харилцаа, холбоо	Цэнхэр	117/190/223	50/10/0/0
21		Худалдаа, үйлчилгээ	Цэнхэр	117/190/223	50/10/0/0
22		Барилга, орон сууц, нийтийн аж ахуй	Цэнхэр	117/190/223	50/10/0/0
23		Бизнес регистр	Цэнхэр	117/190/223	50/10/0/0
24		Дэлхийн улс орнуудын хөгжил	Хөх цэнхэр	64/133/197	75/40/0/0

Хэрэглэгчдэд зориулсан лавлагаа:

Аймгийн Статистикийн хэлтсээс гаргаж буй дараахь мэдээлэл, танилцуулга, тооллого, түүвэр судалгааны үр дүнг uvs.nso.mn хаягаар орох болон аймгийн Засаг даргын Тамгын газрын II байранд байрлуулсан электрон самбарыг ашиглан үзэж, холбогдох мэдээллээ авч болно. Үүнд :

- ✦ Аймгийн нийгэм эдийн засгийн байдлын танилцуулгууд
- ✦ Ажиллах хүчний үр дүнгийн танилцуулга
- ✦ Өрхийн нийгэм эдийн засгийн түүвэр судалгааны үр дүн
- ✦ 2010 оны Хүн ам орон сууцны тооллогын үр дүн, сум, багаар
- ✦ Аж ахуйн нэгжийн тооллогын үр дүн, аймгуудаар, сумдаар, 2010 он
- ✦ Судалгааны үр дүнгүүд
- ✦ 2013-2017 оны ХАА-н салбарын танилцуулга,
- ✦ 2013 -2017 оны Хүн ам, өрхийн төлөв байдал сэдэвт танилцуулга
- ✦ 2013-2017 оны Аймгийн үйлдвэр, үйлчилгээний салбарын танилцуулга
- ✦ 2013-2017 оны Хүн амын ажил эрхлэлтийн танилцуулга
- ✦ Аймгийн ДНБ үйлдвэрлэлт-2014 онд
- ✦ 2016 оны Статистикийн эмхэтгэл
- ✦ 2016 оны сар бүрийн танилцуулгууд
- ✦ 2017 оны сар бүрийн танилцуулгууд
- ✦ 2018 оны сар бүрийн танилцуулгууд
- ✦ Хүн амын хүрээлэн буй орчны танилцуулга
- ✦ Статистикийн эмхэтгэл /сүүлийн 10 жил/ 2008-2017 он
- ✦ 2019 оны сар бүрийн танилцуулгууд

Улс, аймгийн мэдээлэл авах хаяг: uvs.nso.mn www.uvs.gov.mn

Мэдээллийн сангаас авах бол: www.1212.mn

Увс аймгийн Статистикийн хэлтсийн ажилтнуудтай харилцах хаяг :

uvs@nso.mn/ албаны хаяг /

Утас: 70452322,70453316, 99906004, 89610610, 95059079, 99760175,99673065,94000570, 95458359






III. ХҮН АМ


3.1 Хүн амын тоо

Аймгийн хэмжээнд 2019 оны эхний 4 сард 610 эх амаржиж, 615 хүүхэд төрж, мөн нас баралт 167 болж, өмнөх оны мөн үеэс амаржсан эх 1 (0.2%) -ээр, төрсөн хүүхэд 1 (0.2%) –ээр, нас баралт 29 (21.0%)-өөр тус тус нэмэгджээ. 1000 хүнд ноогдох төрөлт 7.4, нас баралт 2.0, цэвэр өсөлт 5.4 болов. Өмнөх оны мөн үеэс 1000 хүнд ноогдох төрөлт 0.1, цэвэр өсөлт 0.4 пунктээр тус тус буурч, нас баралт 0.3 пунктээр нэмэгджээ.

Зураг 3.1 Төрсөн хүүхдийн тоо, онуудаар



Зураг 3.2 1000 хүнд ноогдох төрөлт, нас баралт, цэвэр өсөлт, жил бүрийн эхний 4 сарын байдлаар



1000 хүн амд ноогдох төрөлтийн тоо өмнөх 3 жилийн дунджаас 0.5 пунктээр буурч, нас баралтын тоо 0.2 пунктээр өсчээ.

Гэрийн төрөлт 4 гарчээ. Нийт нас баралтын 15.6 хувийг эмнэлгийн нас баралт эзэлж өмнөх оны мөн үеэс 2.7 пунктээр буурсан байна.




IV. ХӨДӨЛМӨР

4.1 Шинэ ажлын байр болон бүртгэлтэй ажилгүйчүүд

Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй хүний тоо 757 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 95 (11.2 %) хүнээр буурсан байна. Аймгийн хэмжээнд 421 эмэгтэй ажил идэвхитэй эрж байгаа нь ажилгүйчүүдийн 55.6 хувийг эзэлж байна.

Оны эхний 4 сард бүртгүүлсэн, ажил идэвхитэй эрж байгаа ажилгүйчүүдийн тоо өмнөх 3 жилийн дунджаас 263 (25.8 %) ажилгүйчүүдээр буурсан байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 16 (2.1 %) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

Зураг 4.1 Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо, сүүлийн 4 жилээр



Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт энэ онд 831 ажилгүй иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан ажилгүйчүүдээс 131 иргэн ажилд зуучлагдан орж, 670 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагджээ.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 15-24 насны 15.6 хувь, 25-34 насны 38.2 хувь, 35-44 насны 24.6 хувь, 45-54 насны 17.6 хувь, 55-59 насны 3.6 хувь, 60 дээш насны ажилгүйчүүд 0.5 хувийг эзэлж байна. Ажилгүйчүүдийн 26.2 хувь нь дээд, 13.3 хувь нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 51.1 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд боловсролтой, 9.4 хувь нь бага болон боловсролгүй хүмүүс эзэлж байна.

Зураг 4.2 Бүртгэлтэй ажилгүйчүүд боловсролын түвшингээр




Энэ онд 292 ажлын байрны захиалга ирсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 60 (25.9 %) нэгжээр өссөн байна. 244 иргэн ажилд зуучлагдан орсон бөгөөд үүнээс түр ажлын шинэ байранд 43 иргэн, байнгын ажлын шинэ байранд 94 иргэн орсон байна.

Зураг 4.3 Ажлын байрны захиалга, ажилд орсон хүний тоо




Ажлын байрны захиалгыг эдийн засгийн салбарын ангиллаар нь авч үзвэл: боловсролд 27 (9.2 %) , барилгад 35 (12.0 %) , үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт 171 (58.6 %) , бусад салбарт 59 (20.2 %) захиалга ирсэн байна.

Зураг 4.4 Ажлын байрны захиалга салбарын ангиллаар



Бүртгэлтэй ажилгүйчүүдээс ажилд зуучлагдан орсон иргэдийг салбараар нь авч үзвэл боловсруулах үйлдвэрлэлд 20 (8.2 %) , үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт 158 (56.3 %) , боловсролд 16 (6.6 %) , бусад салбарт 50 (24.9 %) иргэд ажилд орсон байна.

Зураг 4.5 Бүртгэлтэй ажилгүйчүүдээс ажилд орсон иргэд, салбарын ангиллаар



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

Бүртгэлтэй ажилгүй иргэн: Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.



V. ӨРХИЙН АМЬЖИРГАА

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2019 оны 1 дүгээр улирлын судалгаагаар нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого 1.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 116.6 (11.3%) мянган төгрөгөөр өслөө. Үүнд хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 10.7 (11.2%) мянган төгрөгөөр буурсан хэдий ч цалин хөлсний орлого 58.5 (10.5%) мянган төгрөг, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого 30.4 (34.5%) мянган төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

5.1. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, эх үүсвэр, Улсын дунджаар, Жил бүрийн 1,2,3,4 дугаар улирлаар

	Орлогын төрөл								Бусдаас үнэгүй авсан	Хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн
	Нийт орлого	Мөнгөн орлого - Бүгд	Цалин хөлс	Тэтгэвэр, тэтгэмж	мал аж ахуйн үйлдвэрлэлийн орлого	Газар тариалангийн үйлдвэрлэлийн орлого	Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл үйлчилгээний Бусад орлого	Бусад		
	төгрөг									
2015										
I-III	1 049 551	941 460	490 570	152 167	112 871	3 739	91 018	91 095	51 410	56 681
IV-VI	1 068 028	975 715	520 912	162 070	98 203	1 490	93 769	99 271	45 736	46 577
VII-IX	1 050 777	937 675	507 567	168 100	94 638	5 605	72 897	88 868	55 310	57 792
X-XII	936 133	848 842	461 323	164 324	78 603	2 381	68 246	73 246	47 155	40 136
2016										
I-III	935 625	849 482	476 942	154 165	58 889	2 225	75 975	81 286	52 189	33 954
IV-VI	970 388	874 392	488 310	160 626	64 437	3 462	74 130	83 427	49 553	46 443
VII-IX	937 053	853 279	479 549	165 373	60 508	2 048	67 878	77 923	45 198	38 576
X-XII	914 900	841 844	454 247	179 480	59 917	1 135	67 949	79 116	40 037	33 019
2017										
I-III	976 824	893 340	504 555	176 984	64 499	2 249	64 683	76 370	48 829	34 655
IV-VI	1 032 112	926 436	511 613	184 523	69 610	1 072	68 274	91 344	55 648	50 028
VII-IX	1 018 563	929 369	525 074	177 750	68 378	1 229	72 912	84 026	48 210	40 984
X-XII	1 041 080	950 032	501 252	186 400	87 060	2 433	86 817	86 070	52 902	38 146
2018										
I-III	1 132 259	1 030 919	556 892	201 109	84 724	3 358	95 235	89 601	61 914	39 426
IV-VI	1 147 242	1 053 618	558 037	206 932	91 322	1 471	96 731	99 125	51 418	42 206
VII-IX	1 168 532	1 074 805	588 770	205 884	91 416	4 444	82 651	101 640	52 426	41 301
X-XII	1 201 880	1 110 983	599 094	210 777	103 222	3 017	84 092	110 761	48 791	42 106
2019										
I-III	1 260 167	1 147 486	615 344	216 293	113 640	4 836	84 570	112 803	65 520	47 161

Нэг өрхийн сарын дундаж бодит (үнийн нөлөөллийг арилган тооцсон) мөнгөн орлогын хэмжээ 2019 оны 1 дүгээр улиралд 1.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 44.5 (4.3%) мянган төгрөгөөр өслөө. Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага 2019 оны 1 дүгээр улиралд 1.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 165.1 (15.6%) мянган төгрөгөөр өслөө. Үүнд хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусад зарлага 132.2 (16.7%) мянган төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Нэг өрхийн сарын дундаж бодит (үнийн нөлөөллийг арилган тооцсон) мөнгөн зарлагын хэмжээ 2019 оны 1 дүгээр улиралд 1.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 88.2 (8.3%) мянган төгрөгөөр өссөн байна.

5.3. НЭГ ӨРЖИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА, Зарлагын төрөл улсын дунджаар жил бүрийн 1,2,3,4 дугаар улирлаар

	Нийт зарлага төгрөг	Зарлагын төрөл						Бусдаас үнэгүй авсан Хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн	Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн
		Мөнгөн зарлага - Бүгд	Хүнсний зүйлийн зарлага	Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага	Бусад зарлага	Бусдад өгсөн бэлэг, тусламж	Бусдаас үнэгүй авсан		
2015									
I-III	1 071 366	963 275	252 329	592 370	93 765	24 811	51 410	56 681	
IV-VI	1 071 545	979 232	244 101	619 760	95 959	19 142	45 736	46 577	
VII-IX	1 049 666	936 564	237 051	578 868	97 645	23 000	55 310	57 792	
X-XII	945 886	858 595	208 777	538 216	90 093	21 509	47 155	40 136	
2016									
I-III	1 051 104	964 961	214 613	649 236	81 955	19 157	52 189	33 954	
IV-VI	1 044 911	948 915	219 517	625 438	83 168	20 792	49 553	46 443	
VII-IX	1 009 928	926 154	213 839	607 228	86 086	19 001	45 198	38 576	
X-XII	971 084	898 028	205 789	584 056	87 301	20 882	40 037	33 019	
2017									
I-III	1 023 487	940 003	220 970	605 903	91 178	21 952	48 829	34 655	
IV-VI	1 107 731	1 002 055	227 245	662 488	91 436	20 886	55 648	50 028	
VII-IX	1 108 567	1 019 373	238 115	668 115	94 830	17 828	48 210	40 984	
X-XII	1 119 942	1 028 894	227 712	677 085	97 674	26423.0	52 902	38 146	
2018									
I-III	1 160 112	1 058 772	236 747	684 239	109 240	28 546	61 914	39 426	
IV-VI	1 192 392	1 098 768	244 177	713 503	113 489	27 599	51 418	42 206	
VII-IX	1 216 990	1 123 263	241 323	748 017	109 867	24 056	52 426	41 301	
X-XII	1 237 397	1 146 500	246 525	759 906	114 252	24 817	48 791	42 106	
2019									
I-III	1 336 535	1 223 854	266 337	798 727	126 940	31 850	65 520	47 161	

Өрхүүдийг мөнгөн орлого, зарлагаар нь бүлэглэн авч үзвэл, 2019 оны 1 дүгээр улиралд 300.0 мянган төгрөгөөс доош орлоготой өрх 55.1 (6.1%) мянга, мөн энэ хэмжээний зарлагатай өрх 27.1 (3.0%) мянга, 300.0-500.0 мянган төгрөгийн орлоготой өрх 113.7 (12.6%) мянга, мөн энэ хэмжээний зарлагатай өрх 89.3 (9.9%) мянга, 500.0-900.0 мянган төгрөгийн орлоготой өрх 268.1 (29.7%) мянга, мөн энэ хэмжээний зарлагатай өрх 249.1 (27.6%) мянга байна. Харин 2.1 сая төгрөгөөс дээш орлоготой өрх 86.6 (9.6%) мянга, мөн энэ хэмжээний зарлагатай өрх 108.3 (12.0%) мянга байна.

5.2. НЭГ ӨРЖИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГЫН БҮТЭЦ, эх үүсвэр, Суурьшлаар ,2018,1-2019- 1 дугаар улирлаар хот, хөдөөгөөр

	Нийт орлого	Орлогын төрөл							Бусдаас үнэгүй авсан Хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн	Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн
		Мөнгөн орлого - Бүгд	Цалин хөлс	Тэтгэвэр, тэтгэмж	Мал аж ахуйн үйлдвэрлэл ийн орлого	Газар тариалангийн үйлдвэрлэл ийн орлого	Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	Бусад орлого		
Төгрөг										
2018, 1 дугаар улирлаар										
Аймгийн төв	1 097 546	1 031 584	567 306	198 070	20 521	5 291	128 369	112 027	55 435	10 527
Сумын төв	949 385	812 554	424 683	189 173	57 474	2 906	64 316	74 002	81 819	55 012
Хөдөө	932 961	716 090	98 765	155 793	418 058	6 115	6 739	30 620	63 338	153 533
2018, 2 дугаар улирлаар										
Аймгийн төв	1 072 393	1 005 493	527 150	211 543	28 688	2 840	114 173	121 099	53 555	13 345
Сумын төв	975 582	847 334	444 462	201 003	62 795	3 372	61 985	73 717	65 193	63 055
Хөдөө	970 659	755 039	96 065	155 616	438 387	612	13 766	50 593	53 639	161 981
2018, 3 дугаар улирлаар										
Аймгийн төв	1 094 091	1 024 903	547 285	216 981	25 547	6 129	105 493	123 468	55 779	13 409
Сумын төв	997 386	876 790	440 796	197 603	64 636	15 048	78 625	80 082	72 462	48 134
Хөдөө	1 011 049	783 238	122 145	166 352	435 660	701	6 904	51 476	53 634	174 177
2018, 4 дугаар улирлаар										
Аймгийн төв	1 144 043	1 088 953	615 579	210 973	25 077	938	109 204	127 182	43 427	11 663
Сумын төв	1 052 447	940 625	486 908	199 111	92 725	4 606	72 263	85 012	51 096	60 726
Хөдөө	1 029 689	817 922	106 513	163 936	478 384	9 230	13 706	46 153	44 024	167 743
2019, 1 дугаар улирлаар										
Аймгийн төв	1 208 185	1 131 812	627 899	233 380	24 921	5 314	117 454	122 844	63 337	13 036
Сумын төв	1 155 696	1 032 265	525 670	216 325	90 330	5 034	73 362	121 544	59 983	63 448
Хөдөө	1 101 188	855 078	89 598	162 457	542 119	15 419	10 418	35 067	54 167	191 943

5.2. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГЫН БҮТЭЦ, эх үүсвэр, Суурьшлаар 2018,1-2019- 1 дугаар улирал хот, хөдөөгөөр

	Нийт орлого	Орлогын төрөл							Бусдаас үнэгүй авсан Хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн	Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн
		Мөнгөн орлого - Бүгд	Цалин хөлс	Тэтгэвэр, тэтгэмж	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн орлого	Газар тариалангийн үйлдвэрлэлийн орлого	Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	Бусад орлого		
дүнд эзлэх хувь										
2018, 1 дугаар улирлаар										
Аймгийн төв	100.0	94.0	54.5	19.7	2.0	0.2	9.8	7.8	5.0	1.0
Сумын төв	100.0	85.6	44.7	19.9	6.1	0.3	6.8	7.8	8.6	5.8
Хөдөө	100.0	76.7	10.6	16.7	44.8	0.6	0.7	3.3	6.8	16.5
2018, 2 дугаар улирлаар										
Аймгийн төв	100.0	93.8	49.2	19.7	2.7	0.3	10.6	11.3	5.0	1.2
Сумын төв	100.0	86.9	45.6	20.6	6.4	0.3	6.4	7.6	6.7	6.4
Хөдөө	100.0	77.8	9.9	16.0	45.2	0.1	1.4	5.2	5.5	16.7
2018, 3 дугаар улирлаар										
Аймгийн төв	100.0	93.7	52.7	19.8	2.3	0.6	9.7	11.3	5.1	1.2
Сумын төв	100.0	87.9	44.2	19.8	6.5	1.5	7.9	8.0	7.3	4.8
Хөдөө	100.0	77.5	12.1	16.4	43.1	0.1	0.7	5.1	5.3	17.2
2018, 4 дугаар улирлаар										
Аймгийн төв	100.0	95.2	53.8	18.4	2.2	0.1	9.6	11.1	3.8	1.0
Сумын төв	100.0	89.4	46.3	18.9	8.8	0.4	6.9	8.1	4.8	5.8
Хөдөө	100.0	79.4	10.3	15.9	46.5	0.9	1.3	4.5	4.3	16.3
2019, 1 дугаар улирлаар										
Аймгийн төв	100.0	93.7	52.0	19.3	2.1	0.4	9.7	10.2	5.2	1.1
Сумын төв	100.0	89.3	45.5	18.7	7.8	0.4	6.4	10.5	5.2	5.5
Хөдөө	100.0	77.7	8.1	14.8	49.2	1.4	1.0	3.2	4.9	17.4

5.3. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА, 2018,1-2019, 1 дугаар улирлаар хот, хөдөөгөөр

	Нийт зарлага	Зарлагын төрөл					Бусдаас үнэгүй авсан Хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн	Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн
		Мөнгөн зарлага - Бүгд	Хүнсний зүйлийн зарлага	Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага	Бусад зарлага	Бусад өгсөн бэлэг, тусламж		
төгрөг								
2018, 1 дугаар улирлаар								
Аймгийн төв	1 154 605	1 088 643	235 775	717 334	107 502	28 032	55 435	10 527
Сумын төв	1 110 961	974 130	190 584	645 935	109 565	28 046	81 819	55 012
Хөдөө	994 314	777 443	129 103	498 225	120 692	29 423	63 338	153 533
2018, 2 дугаар улирлаар								
Аймгийн төв	1 151 214	1 084 314	236 384	717 129	104 161	26 640	53 555	13 345
Сумын төв	1 101 595	973 347	194 558	640 046	110 126	28 617	65 193	63 055
Хөдөө	1 011 187	795 567	127 020	503 229	126 849	38 469	53 639	161 981
2018, 3 дугаар улирлаар								
Аймгийн төв	1 157 949	1 088 761	232 686	725 932	108 059	22 084	55 779	13 409
Сумын төв	1 128 417	1 007 821	204 191	674 214	100 871	28 545	72 462	48 134
Хөдөө	1 068 332	840 521	127 176	564 320	114 930	34 095	53 634	174 177
2018, 4 дугаар улирлаар								
Аймгийн төв	1 232 816	1 177 726	243 386	797 184	112 296	24 860	43 427	11 663
Сумын төв	1 155 538	1 043 716	189 029	703 589	119 095	32 003	51 096	60 726
Хөдөө	1 056 395	844 628	121 899	556 346	132 840	33 543	44 024	167 743
2019, 1 дугаар улирлаар								
Аймгийн төв	1 329 369	1 252 996	284 962	806 019	131 297	30 718	63 337	13 036
Сумын төв	1 300 541	1 177 110	212 119	791 434	130 433	43 124	59 983	63 448
Хөдөө	1 220 701	974 591	147 274	651 950	139 345	36 022	54 167	191 943

5.4. НЭГ ӨРЖИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГЫН БҮТЭЦ, 2018,1-2019,1 дугаар улирлаар хот, хөдөөгөөр хот,

Нийт зарлага дүнд эзлэх хувь	Зарлагын төрөл						Бусдаас үнэгүй авсан	Өөрийн хувийн аж ахуйгаас
	Мөнгөн зарлага -	Хүнсний	Хүнсний бус	Бусад зарлага	Бусдад өгсөн			
2018, 1 дугаар улирлаар								
Аймгийн төв	100.0	94.3	20.4	62.2	9.3	2.4	4.8	0.9
Сумын төв	100.0	87.7	17.2	58.1	9.9	2.5	7.4	4.9
Хөдөө	100.0	78.2	13.0	50.1	12.1	3.0	6.4	15.4
2018, 2 дугаар улирлаар								
Аймгийн төв	100.0	94.1	20.5	62.3	9.0	2.3	4.7	1.2
Сумын төв	100.0	88.4	17.7	58.1	10.0	2.6	5.9	5.7
Хөдөө	100.0	78.7	12.6	49.8	12.5	3.8	5.3	16.0
2018, 3 дугаар улирлаар								
Аймгийн төв	100.0	94.0	20.1	62.7	9.3	1.9	4.8	1.2
Сумын төв	100.0	89.3	18.1	59.8	8.9	2.5	6.4	4.3
Хөдөө	100.0	78.7	11.9	52.8	10.8	3.2	5.0	16.3
2018, 4 дугаар улирлаар								
Аймгийн төв	100.0	95.5	19.7	64.7	9.1	2.0	3.5	1.0
Сумын төв	100.0	90.4	16.4	60.9	10.3	2.8	4.4	5.2
Хөдөө	100.0	79.9	11.5	52.6	12.6	3.2	4.2	15.9
2019, 1 дугаар улирлаар								
Аймгийн төв	100.0	94.2	21.4	60.6	9.9	2.3	4.8	1.0
Сумын төв	100.0	90.5	16.5	60.9	10.0	3.3	4.6	4.9
Хөдөө	100.0	79.9	12.1	53.4	11.4	3.0	4.4	15.7




VI НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого энэ оны эхний 4 сард 6369.0 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1490.7 (30.6%) сая төгрөгөөр, сангийн зарлага 17604.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2585.1 (17.2%) сая төгрөгөөр тус тус өслөө.

Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үеэс 2585.1 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 2097.7 сая төгрөгөөр өссөн нь гол нөлөө үзүүлжээ.


Зураг 6.1 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага эхний 4 сард, сая төгрөг



Эрүүл мэндийн даатгалын сангаас бусад нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг Түргэн 2.8, Бөхмөрөн 0.7 хувиар тус тус тасалж, бусад сумууд 0.1 – 27.5 хувиар давуулан биелүүлсэн байна.


Нийгмийн даатгалын сан 909.2 сая төгрөгийн авлагатай байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 32.5 (3.7%) сая төгрөгөөр өссөн байна. Нийт авлагын 20.8 хувийг төсөвт байгууллагын өглөг эзэлж байна.

Зураг 6.2 Нийгмийн даатгалын сангийн орлого, сангуудаар, сая төгрөг




Сангуудаар авч үзвэл өмнөх оны мөн үеэс тэтгэврийн даатгалын сангийн орлого 997.7 (31.6%), эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 262.7 (25.9%), ҮОМШӨ –ний даатгалын сангийн орлого 90.0 (32.7%), тэтгэмжийн даатгалын сангийн орлого 115.5 (32.7%), ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 24.9 (32.7%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг 6.3 Нийгмийн даатгалын сангийн зарлага, сангуудаар, сая төгрөг



Өмнөх оны мөн үеэс тэтгэврийн даатгалын сангийн зарлага 2097.7 (15.9%), эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 390.5 (34.9%), тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 115.5 (19.7%) сая төгрөгөөр тус тус өсч, үйлдвэрийн осол мэргэжлээс шатгаалах өвчний даатгалын сангийн зарлага 2.1 (6.8%), ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 16.4 (14.7%) сая төгрөгөөр буурсан байна.


Зураг 6.4 Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц, хувиар



Нийгмийн халамжийн сангаас энэ оны эхний 4 сард 31.3 мянган хүнд 4927.3 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеэс олгосон тэтгэвэр тэтгэмж 3826.0 (43.7%) сая төгрөгөөр буурсан байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт энэ оны эхний 4 сард 1.7 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 24 (1.4%) хүнээр, олгосон тэтгэвэр 78.8 (7.8%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг 6.5 Халамжийн сангийн зарцуулалт, жил бүрийн эхний 4 сарын байдлаар, сая төгрөг



Энэ оны 4 сард цалинтай ээж хөтөлбөрт 4326 хүн хамрагдаж, 885.8 сая төгрөг, хүнс тэжээлийн тусламжинд 5876 хүн хамрагдаж, 398.3 сая төгрөгийн тусламж авчээ.

Асрамжийн газар нийт 17 хүн асруулж байгаа бөгөөд 12 эмэгтэй байна. Асрамжийн үйл ажиллагаанд нийт 71.6 сая төгрөгийг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 13.2 (22.6%) сая төгрөгөөр өсч, асруулагчийн тоо өнгөрсөн оны түвшинд байна.

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Даатгуулагч: Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг ойлгоно.

Нийгмийн даатгал: Иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын төрлүүд: Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан: Энэ нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн халамж: Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг ойлгоно.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд /хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл /-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгийг ойлгоно.


Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгийг ойлгоно.




VIII. ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдэл эхний 4 сард 11, 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 15 гарч, 1000 амьд төрөлтөнд нялхсын эндэгдэл 17.9, 5 хүртэлх насны эндэгдэл 24.4 ноогдож байна.

Зураг 8.1 1000 амьд төрөлтөнд ноогдох нялхсын эндэгдэл, сараар



Зураг 8.2 1000 амьд төрөлтөнд ноогдох нялхсын ба 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл



1000 амьд төрөлтөнд ноогдох нялхсын эндэгдэл Бөхмөрөн суманд 1000.0, Завхан суманд 500.0, Тэс суманд 333.3, Улаангом суманд 13.3 ноогдож, аймгийн дундаж 24.4 байна.

Зураг 8.3 1000 амьд төрөлтөнд ноогдох нялхсын эндэгдлийн түвшин, сумаар




Зураг 8.4 1000 амьд төрөлтөнд ноогдох 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, сумаар



Эхний 4 сарын байдлаар осол гэмтлийн улмаас 21 хүн нас барж, өвчлөгчдийн тоо 201 болсон нь өмнөх оны мөн үеэс өвчлөгчдийн тоо 26 (11.5%)-аар буурч, нас баралтын тоо 6 хүнээр өссөн байна. Өмнөх 3 жилийн дунджаас осол гэмтлээр өвчлөгчдийн тоо 26.1 хувиар буурч, осол гэмтлийн нас баралтын тоо 53.3 хувиар өссөн байна.

Зураг 8.5 Осол гэмтлийн өвчлөл, нас баралтын тоо




Хорт хавдрын өвчлөл 63 гарч өмнөх оны мөн үеэс 19 (43.2%) -өөр өсч, нас баралт 55 гарсан нь өмнөх оны мөн үеэс 2 (3.8%) - оор өсчээ.

Зураг 8.6 Хорт хавдрын өвчлөл, нас баралтын тоо



Энэ оны эхний 4 сард халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 175 болж өнгөрсөн оны мөн үеэс 104 (37.3%) хүнээр буурч, өмнөх 3 жилийн мөн үеийн дунджаас 42.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 8.7 Халдварт өвчний гаралт, тоогоор




Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнийг хувиар авч үзвэл салхинцэцэг өвчин нийт халдварт өвчний 17.7 хувийг, БЗХӨ 57.1, сүрьеэ 8.6, гепатит 2.3, цусан суулга 9.7, бусад халдварт өвчин 4.6 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс БЗХӨ - ний эзлэх хувь 15.2, сүрьеэ 4.3, гепатит 0.1 пунктээр өсч, салхинцэцэг 29.3 пунктээр буурчээ.

Зураг 8.8 Хүн амд зонхилон тохиолдох халдварт




Зураг 8.9 Хүн амд зонхилон тохиолдох халдварт




10000 хүн тутмаас 21 нь халдварт өвчнөөр өвчилж байгаа бөгөөд Өлгий 65.9, Улаангом 36.4, Давст 23.7 байгаа нь аймгийн дунджаас 2.8 – 45.0 процентийг өндөр, бусад сумдад аймгийн дунджаас 6.0 – 17.0 процентийг бага байна. Завхан, Зүүнговь сумдад халдварт өвчний тохиолдол гараагүй байна.

Зураг 8.10 10000 хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнүүд



Зураг 8.11 10000 хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнүүд



Амбулаториор 134.9 мянган хүнд үзлэг хийгдэж, 7.6 мянган хүн хэвтэн эмчлэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс амбулаториор үйлчлүүлсэн хүн 0.2 мянган хүнээр өсч, хэвтэн эмчлүүлэгчид 0.3 мянган хүнээр буурчээ.

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

ЭРҮҮЛ МЭНД

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байгааг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нялхсын эндэгдлийн түвшин: Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин: Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшин: Тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог тухайн хугацааны дундаж хүн амын тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндэснийг хамруулна.



ХИ. БАЙГАЛЬ ОРЧИН

11.1 Цаг уурын байдал

Энэ оны 4 дүгээр сард агаарын температур дунджаар Завхан, Наранбулаг сумдад 8.3 - 8.7 градустай, бусад сумдад 2.2-аас +6.9 градус дулаан байсан байна. Хөрсний гадаргын дундаж температур Сагил суманд хамгийн дулаан +12.8 градус байсан бол хамгийн бага температуртай нь Цагаанхайрхан суманд +1.9 градус байжээ. Салхины хамгийн их хурд Өмнөговь, Завхан, Баруунтуруун, Малчин, Өндөрхангай, Улаангом суманд 21 - 26 м/сек хүрсэн бөгөөд 10 м/сек-ээс их салхитай өдөр Өмнөговь 29, Бөхмөрөн, Завхан сумдад 23, Өндөрхангай 18, Баруунтуруун 17, Наранбулаг 13, Малчин 11, бусад сумдад 4-10 өдөр байв.Хяргас суманд 14.0 мм хур тунадас орсон нь бусдаас илүү байна.Өнгөрсөн оны мөн үеэс хүхэрлэг хий 0.003 мг/м³ –аар, азотын давхар исэл 0.001 мг/м³ –аар их, тоос 0.059 мг/м³ –аар бага байлаа.

11.2 Аюулт үзэгдэл осол

2019 оны 4 дүгээр сард гамшиг ослын тохиолдол гараагүй, объектын гал түймэр 7, ой, хээрийн гал түймэр 1 тохиолдол гарсан байна.Гал түймрийн улмаас иргэдийн хувийн өмчинд 7.0 сая төгрөгийн хохирол учирчээ.

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

БАЙГАЛЬ ОРЧИН

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.




XII. ГЭМТ ХЭРЭГ, ШҮҮХ

12.1 Гэмт хэргийн статистик

Энэ оны эхний 4 сард бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 93 болж өнгөрсөн оны мөн үеэс 27 (22.5%)-оор буурчээ. Гэмт хэргийн улмаас 32 хүн гэмтэж, 94 иргэн хохирсон байна.


Зураг 12.1 Гэмт хэргийн гаралт, жил бүрийн эцэст



Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 38.5, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 18.0, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 50.0, тээврийн хэрэгслийн ашиглалт ХАБ-ын эсрэг гэмт хэрэг 33.3, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 33.3 хувиар тус тус буурчээ.

Гэмт хэргийг үйлдэгдсэн байдлаар нь авч үзвэл гэр бүлийн хүчирхийллийн улмаас 8, согтуугаар үйлдэгдсэн 27, гудамж талбайд 9, гэр орон сууцанд 38, бүлэглэн үйлдсэн 5 гэмт хэрэг бүртгэгджээ.


Зураг 12.2 Гэмт хэргийн гаралт, төрлөөр, тоо



Гэмт хэрэг үйлдсэн хүний тоо 58 болж, өмнөх оноос 13 хүнээр буурч эмэгтэй хүн оролцсон 6 хэрэг, хүүхэд оролцсон 6 хэрэг гарсан байна.

Гэмт хэргийн улмаас 137.1 сая төгрөгийн хохирол учраад байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 28.2 (17.1%) сая төгрөгөөр буурч, иргэд байгууллагад учруулсан нийт хохирлын 22.0 хувийг буюу 30.2 сая төгрөгийг нөхөн төлүүлжээ. Хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын үед хөрөнгө битүүмжлээгүй байна.

Зураг 12.3 Хохирол, нөхөн төлөлт сая.төгрөг




Энэ оны эхний 4 сард нийт гэмт хэргийн дийлэнх нь Улаангом суманд үйлдэгдсэн бөгөөд нийт 46 тохиолдол гарч, өнгөрсөн оны мөн үеэс 34.3 хувиар буурчээ. Аймгийн хэмжээнд нийт 4220 зөрчил шийдвэрлэсэн нь өнгөрсөн оноос 604 (16.7%) зөрчлөөр өссөн байна. Энэ оны эхний 4 сард 89 хүн тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулж торгуулжээ.

12.2 Шүүхийн статистик


Аймгийн шүүхийн тамгийн газраас ирүүлсэн мэдээллээр, энэ оны 4 сард шүүхээр нийт 245 хэрэг шийдвэрлэжээ. Шүүхийн төрлөөр авч үзвэл эрүүгийн хэрэг 53, иргэний хэрэг 175, давж заалдах шатны шүүхээр 13, захиргааны 4 хэрэг тус тус шийдвэрлэсэн байна.

Зураг 12.4 Шүүхээр шийдвэрлэсэн гэмт хэргийн тоо, шүүхийн төрлөөр



Шүүхээр ял шийтгүүлсэн нийт 41 иргэн, үүнээс хорих ял шийтгүүлсэн 8 иргэн байна.

Зураг 12.5 Ял шийтгүүлсэн хүний тоо, насны бүлгээр



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

ГЭМТ ХЭРЭГ

Гэмт хэрэг: Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ.

18, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18, түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулж тооцно.

Гэмт хэргийн хохирогч: Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг ойлгоно /МУ-ын "Эрүүгийн байцаан шийтгэх" хуулийн 42.1 дэх заалт/.

Учирсан хохирол: Гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эдийн болон эдийн бус хөрөнгийн эрхэд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Нөхөн төлбөр: Хохирлын нөхөн төлүүлэлт нь хүний эрх, эрх чөлөөний хир хэмжээ, учруулсан хор уршигт дүйцэхүйц байх ёстой бөгөөд хохирогчийн эрх, эрх чөлөө, хувийн байдал, гэр бүл, эд хөрөнгө, хөдөлмөр эрхлэлт, сургууль, боловсролын түвшинг аль болох өмнө нь байсан хэмжээнд сэргээн бүрдүүлэхийг ойлгоно.

Сэжигтэн: МУ-ын "Эрүүгийн байцаан шийтгэх" хуулийн 35.1-д заасны дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч энэ хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу эрүүгийн хэрэг үүсгэж, дор дурдсан этгээдийг сэжигтнээр тооцож, үндэслэл бүхий тогтоол гаргана уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдсэн дор нь барьсан; гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан; уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон; уг этгээд хэргээ илчлэн ирсэн гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол.

Яллагдагч: МУ-ын "Эрүүгийн байцаан шийтгэх" хуулийн 36.1-д заасны дагуу энэ хуулиар тогтоосон журмын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонгосон этгээдийг ойлгоно.




XIV. МӨНГӨ, БАНК

Монгол банкны эх үүсвэрээр 17.3 тэрбум төгрөг зузаатгалаар авч 163.4 тэрбум төгрөг гүйлгээнд гаргаснаас 152.8 тэрбум төгрөгийг буюу гаргасан мөнгөнөөс 93.5 хувийг эргүүлэн татсан байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зузаатгалаар авсан мөнгө 10.1 (36.7 %) тэрбум төгрөгөөр, гүйлгээнд гаргасан мөнгө 13.6 (7.7 %) тэрбум төгрөгөөр, гүйлгээнээс татсан мөнгө 4.5 (2.9 %) тэрбум төгрөгөөр буурсан байна.


Зээлийн өрийн үлдэгдэл 193.0 тэрбум төгрөгт хүрч, үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 2.5 тэрбум төгрөг болж ноднингийн мөн үеэс бүх зээлийн үлдэгдэл 15.5 (10.6 %) тэрбум төгрөгөөр өссөн бол хугацаа хэтэрсэн зээл 1.4 (36.1 %) тэрбум төгрөгөөр буурсан байна. 7.7 тэрбум төгрөгийн найдваргүй зээл байгаа нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.0 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 1.0 тэрбум төгрөгөөр буюу 14.9 хувиар өссөн байна. Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл өмнөх 3 жилийн дунджаас 26.2 (15.6 %) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 14.1 Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл, тэрбум төгрөг



Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 109.5 тэрбум төгрөг болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 18.3 (20.1 %) тэрбум төгрөгөөр өссөн байна. Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл өмнөх 3 жилийн дунджаас 31.3 (40.0 %) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 14.2 Хадгаламжийн үлдэгдэл, тэрбум төгрөг



Арилжааны банкууд иргэд, аж ахуй нэгж нийт 22.5 мянган зээлдэгчдэд 63.6 тэрбум төгрөгийн зээлийг олгосон бөгөөд төрлөөр нь авч үзвэл лизингийн зээл 1.0 хувь, хадгаламж барьцаалсан зээл 20.6 хувь, малчны зээл 10.5 хувь, бизнесийн зээл 22.7 хувь, орон сууц, хашаа байшингийн зээл 4.4 хувь, цалингийн зээл 14.1 хувь, тэтгэврийн зээл 15.1 хувь, хэрэглээний зээл 1.1 хувь, төслийн зээл 2.8 хувь, хөрөнгө оруулалтын зээл 5.6 хувь, картын зээл 1.6 хувь, бусад зээл 0.2 хувь, бүлгийн зээл 0.3 хувийг тус тус эзэлж байна. Нийт олгосон зээлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зээлдэгчдийн тоо 13.5 хувь буурч зээлийн хэмжээ 15.1 хувиар өссөн байна. Хадгаламжийн дундаж хүү 11.6 хувь, төгрөгийн

зээлийн дундаж хүү 16.9 хувьтай байгаа бол 1 ам.доллартай харьцах ханш 2642.8 төгрөг байна.



XV ТӨРИЙН САНХҮҮ


15.1 Орон нутгийн төсвийн орлого

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулан тооцсоноор 2019 оны энхий 4 сард аймгийн төсөвт 10.5 тэрбум төгрөг оруулахаас 10.8 тэрбум төгрөгийн орлого орж төлөвлөгөөний биелэлт 102.9 хувьтай, 307.9 (2.9%) сая төгрөгөөр давуулан биелүүллээ.

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулалгүйгээр аймаг өөрөө 3.4 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэхээс 4.6 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 136.9 хувиар биелүүлж, 1251.1 (36.9%) сая төгрөгөөр давуулан биелүүллээ. Үүнээс улсын төвлөрсөн төсөвт 952.8 сая төгрөгийг татвар, орлогын хэлбэрээр төвлөрүүлэхээс 1896.0 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 943.2 (99.0%) сая төгрөгөөр, аймгийн төсөвт өөрийн орлогоор 2.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс 2.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 112.7 хувиар биелүүлж, 307.9 (12.7%) сая төгрөгөөр тус тус давуулан биелүүллээ. Ноднингийн мөн үетэй харьцуулахад аймгийн төвлөрүүлсэн нийт орлого 1295.0 (38.7%) сая төгрөгөөр их, үүнээс улсын төсөвт төвлөрүүлсэн орлого 999.3 (2.1 дахин) сая төгрөгөөр, аймгийн төсөвт төвлөрүүлсэн орлого 295.7 (12.1%) сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.


Оны энхий 4 сард улсын төсөвт төвлөрүүлэх орлогуудаас ААНБ-ын орлогын албан татварын төлөвлөгөө -1.9 (1.4 %) сая төгрөгөөр тасарч, нэмэгдсэн өртгийн татвар 741.6 (2.0 дахин) сая төгрөгөөр, онцгой албан татвар 95.8 (2.5 дахин), ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 87.8 (4.4 дахин), агаарын бохирдлын төлбөр 19.9 (4.4 дахин) сая төгрөгөөр тус тус давж биелэгдсэн байна.

Зураг 15.1 Төсвийн орлогын бүтэц, хувиар




Аймгийн төсвийн орлого өнгөрсөн оны мөн үеэс 38.7 хувиар, өмнөх 3 жилийн дундажтай харьцуулахад 58.2 хувиар тус тус өссөн байна.

Зураг 15.2 Төсвийн орлогын өсөлт бууралт, онуудаар, сая төгрөг



Аймгийн төсвийн нийт зарлагад өөрөө бүрдүүлсэн орлогын эзлэх хувь 21.0 хувь болж өмнөх 3 жилийн дундаас 6.3 пунктээр өссөн байна.


Зураг 15.3 Аймгийн төсвийн зарлагад өөрөө бүрдүүлсэн орлогын эзлэх хувь



15.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Орон нутгийн төсвийн болон улсын төсвийн байгууллагуудын дүнгээр 22.0 тэрбум төгрөгийн зардал гаргасан нь өнгөрсөн оны мөн үеэс 5.9 хувиар, өмнөх 3 жилийн дунджаас 10.4 хувиар тус тус өссөн байна.

Зураг 15.4 Орон нутгийн төсвийн зарлага, сая төгрөг



Зураг 15.5 Төсвийн зарлагын бүтэц, хувь




Төсвийн зардлын 28.5 хувийг төрийн үйлчилгээ, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын үйл ажиллагаанд, 61.1 хувийг боловсрол соёлын үйл ажиллагаанд, 9.1 хувийг эрүүл мэнд, амралт, спортын үйл ажиллагаанд, 0.8 хувийг барилга хот байгуулалтанд, 0.5 хувийг хүн амын хөгжил нийгмийн хамгааллын үйл ажиллагаанд зориулан зарцуулсан байна.

15.3 ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨГЛӨГ, АВЛАГА


Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн байгууллагуудын дүнгээр 2019 оны 4 сард 317.6 сая төгрөгийн өртэй, 94.3 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

Зураг 15.6 Төсөвт байгууллагуудын өглөг , авлага

Төсөвт байгууллагуудын өглөг жил бүрийн 4 сарын эцэст , сая.төгрөг



Төсөвт байгууллагуудын авлага жил бүрийн 4 сарын эцэст, сая.төгрөг




XVI. ГАДААД ХУДАЛДАА


Энэ оны 4 сарын байдлаар импорт 6528.0 мянган америк долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 2172.2 (25.0 %) мянган америк доллараар буурсан байна. Гол нэрээс дурдвал цахилгаан 46736.2 мянган киловатт цаг, авто

бензин 2645.7 тонн, түлш 2996.2 тонн, хивэг 2306 тонн, овъёос 342.6 тонн, банз мод 235.7 м3 тус тус импортоор оруулсан байна.

Зураг.16.1 Нийт импорт,экспорт жил бүрийн эхний 4 сараар мян.ам.доллар



Зураг 16.2 2019 оны эхний 4 сарын нийт импортын гол нэрийн бүтээгдэхүүний үнийн дүн дэх эзлэх хувь



Өнгөрсөн оны мөн үеэс банз мод 195.7м3, жимсний шүүс 181.3 лирт, өнгөлгөөний тоосго 101.1 тонн, хивэг 403 тонн, цахилгаан эрчим хүч 2858.6 мян.квт.цаг-аар тус тус өссөн бол авто бензин 705.3 тонн, дизель түлш 1616.3 тонн, мебель тавилга 173 ширхэг, овъёос 338.6 тонноор буурсан байна.

Энэ оны эхний 4 сарын байдлаар нийт экспорт 3.8 мянган америк долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 21.2 (6.6 д) мянган америк доллараар буурсан байна. Монгол гэр 2 ширхэг, цайны зүйлс 1.4 тонн экспортлогдсон байна.



XVII. ҮНЭ

17.1 Хэрэглээний үнэ


Сар бүрийн 15-21 ний байдлаар хүн амын өргөн хэрэглээний 12 бүлэг, сагсны 238 нэрийн барааны үнийн өөрчлөлтийг сонгогдсон цэгүүдээс судалж сарын инфляци тооцож байдаг. Энэ оны 4-р сарын 15-21 нд судлагдаж буй өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын ерөнхий индекс өнгөрсөн оны мөн үеэс 6.6 хувь өмнөх сараас 0.8, оны эхнээс 3.8 хувь өссөн байна.

Хүснэгт 17.1 Хэрэглээний барааны үнэ тарифын 4-р сарын индекс, хувь


Бүлэг	2019.04/ 2018.04	2019.04/ 2018.12	2019.04/ 2019.03
ЕРӨНХИЙ ИНДЕКС	106.6	103.8	100.8
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	115.1	111.0	102.6
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	103.0	100.9	100.2
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	104.6	101.0	100.1
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	101.7	99.9	97.4
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	103.9	102.5	100.7
06. ЭМ ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	105.9	101.0	100.1
07. ТЭЭВЭР	101.5	100.5	101.2
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	99.2	99.9	99.9
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	104.7	102.3	100.3
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0	100.0
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТ.БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	113.6	102.5	100.0
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	104.3	100.5	100.5

Өмнөх сараас хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 2.6, хувцас бөс бараа, гутлын бүлгийн үнэ 0.1, гэр ахуйн тавилгын бүлгийн үнэ 0.7, эм тарианы бүлгийн үнэ 0.1, тээврийн бүлгийн үнэ 1.2, амралт чөлөөт цагийн бүлгийн үнэ 0.3, бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ 0.5 хувиар өссөн нь үнийн ерөнхий индекс 0.8 хувиар өсөхөд нөлөөллөө.

Зураг 17.1. Хэрэглээний үнийн индекс 4 сар, бүлгээр, хувь




Зураг 17.2. Сүүлийн 4 жилийн индексийг өмнөх сар, оны эхтэй харьцуулсан индекс



Сүүлийн 4 жилийн 4-р сарыг: өмнөх оны эхтэй харьцуулсан индексээс харахад хамгийн өндөр нь 2017 оны 4-р сард 4.5 хувь, хамгийн бага нь 2016 оны 4 сард 0.5, өмнөх сартай харьцуулсан индексээс харахад хамгийн өндөр нь 2017 оны 4 сард 1.7 хувиар өсч байсан бол хамгийн бага нь 2018 оны 4 сард 0.2 хувиар өссөн байна.

Зураг 17.3. Сарын инфляцийн түвшин




Өргөн хэрэглээний 11 бараа, бүтээгдхүүний үнийг 7 хоног бүрийн 3 дахь өдөр цуглуулж өөрчлөлтийг судалж байна. Өмнөх сарын дундаж үнээс мах 6.8-21.2, түлш шатахуун 0.5 - 0.7 хувиар өсч, сүү 0.8 хувиар буурсан байна.




Махны дундаж үнэ:

2019 оны 4 сард хонь үхрийн махны үнэ сарын турш 8500 төгрөг байж, ямааны махны үнэ 4 дэх долоо хоногдоос 1750 төгрөгөөр өссөн байна.

Зураг 17.4. Махны үнэ, долоо хоног, төрлөөр



4-р сард дунджаар 1 кг хонины мах 8500, үхрийн махны үнэ 8500 төгрөг , 1 л шингэн сүү 2000 төгрөг, элсэн чихэр 2400 төгрөг, цагаан будаа 2400, бензин А-80 1844, бензин А-92 1902, дизель түлш 2322 төгрөгийн дундаж үнэтэй байсан байна.



17.2 Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Малын зах зээлийн дундаж үнийн мэдээгээр 2019 оны 4 дүгээр сард атан тэмээ Завхан, Тэс суманд 1.0 сая төгрөг, соёолон үрээ Бөхмөрөн суманд хамгийн их буюу 900.0 мянган төгрөг, Цагаанхайрхан суманд хамгийн бага буюу 500.0 мянган төгрөг, хязаалан шар Тэс суманд хамгийн их буюу 700.0 мянга, Цагаанхайрхан суманд хамгийн бага 550.0 мянган төгрөгийн үнэтэй байна. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Улаангом суманд хамгийн их буюу 200.0 мянган төгрөг, Давст, Цагаанхайрхан суманд хамгийн бага буюу 140.0 мянган төгрөг, нас гүйцсэн эр ямааны дундаж үнэ Өлгий, Тариалан, Цагаанхайрхан суманд хамгийн их буюу 110.0 мянган төгрөг, Хяргас суманд хамгийн бага буюу 80.0 мянган төгрөг байна.



Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээгээр 2019 оны 4 дүгээр сард ноолуурын дундаж үнэ 115.0 мянган төгрөг, ямааны ноолууртай арьсны үнэ 25.0 мянган төгрөг, хонины ноостой нэхий 1000 төгрөг байна.

Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээгээр 2019 оны 4 дүгээр сард 1 тонн үрийн буудайн дундаж үнэ Баруунтуруун суманд 650.0 мянган төгрөг байна.

Боодолтой өвсний дундаж үнэ Улаангом суманд хамгийн их буюу 8.5 мянган төгрөг, Тэс суманд хамгийн бага буюу 4.5 мянган төгрөг, 1 тонн задгай өвсний дундаж үнэ Ховд суманд 140.0 мянган төгрөг байна.

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

ҮНЭ

